

**ЦАХИЛГААН ШАТНЫ ЭД АНГИ, СЭЛБЭГ МАТЕРИАЛЫН
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

2023 оны 08 дугаар сарын 21

Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн А/936 дугаар эрх шилжүүлэх захирамжийн хүрээнд Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шатын засварын ажилд шаардлагатай сэлбэг материалын жагсаалтыг боловсруулав.

1.Байршил: Сүхбаатар дүүргийн 3 дугаар хороо,18-р байрны 1 дүгээр орцны цахилгаан шат

№	Шаардлагатай сэлбэгийн нэр	Тоо хэмжээ	Диаметр	Тайлбар
1	Үндсэн ган татлага	200м	8мм	Шинээр солих

1. Нийтийн зориулалттай орон сууцны барилгын хүн зөөврийн лифтний сэлбэгүүд нь Олон улсын 180 14001, Европын 2014/33/EU, EN 81-20:2014 стандартын шаардлага хангасан байх ёстой.
2. Лифтний сэлбэг материалын угсралтын ажлыг гүйцэтгэхдээ ЗТБХБ сайдын 2008 оны 53 дугаар тушаалаар батлагдсан "Лифтийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм"-ийг баримтална.
3. Лифтний эд ангиудыг суурилуулсны дараа ашиглалтад өгөхийн өмнө туршилтын ажлыг явуулахдаа захиалагч, ашиглалтын байгууллагуудын төлөөлөгчдийг байлцуулан гүйцэтгэнэ.
4. Лифтийг сэлбэг материалуудыг угсрахын өмнө захиалагчид мэдэгдэнэ.
5. Лифтний хонгилын хэсгийн барилгын үндсэн хийц эдлэлд өөрчлөлт оруулах, хучилтын хавтанд нэмэлт ачаалал өгөх, төхөөрөмж угсрах зорилгоор эвдэж гэмтээхийг хориглоно.
6. Гүйцэтгэгч нь лифтний сэлбэг материалын үндсэн үзүүлэлт, марк, хүчин чадлыг тулгаж, шалгах шаардлагатай.
7. Гүйцэтгэгч нь лифтний сэлбэг материалыг нийлүүлж угсралтын ажлыг хийж гүйцэтгэн хүлээлгэж өгнө.